

ТӨРИЙН СОЁЛЫН БА ХЭЛНИЙ БОДЛОГЫН ЗОХИРОЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.Пүрэвсүрэн. ШУТИС-ийн Хүмүүнлэгийн Ухааны Сургууль. Докторант

Түлхүүр үг: соёлын бодлого, соёлын эрх чөлөө, соёлын удирдлага, соёлын бодлогын хэв маяг, хэлний бодлого

Соёлын бодлого ба соёлыг удирдахуй. Соёл бол олон талт, тогтолцоот, ялгаатай, динамик үзэгдэл болохыг өмнө олонтаа өгүүлсэн билээ. Түүний тодорхой хэлбэрийн илэрлийн соёлын онолын анализ нь соёлд хандах хандлага, арга зүйн чиг баримжааны хувьд ч түүнээс хамаараад тун олон янз.

Төрийн бодлогын олон салаа салбарын нэгэн цогц уулзвар зангилгаан дээрх бодлогын нэг бол төрийн соёлын бодлого юм. Энэ нь өөрөө төрийн бодлого, үндсэн хууль болон соёлын талаарх эрх зүйн тулгуур баримт бичгүүдээр биелэлээ олдог соёлын үнэт зүйлс, өвийг хөгжүүлэх, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр соёлын үйл хэргийг төгөлдөржүүлэн тогтвортой байдлыг хангах соёлын салбар дахь төрийн үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээгээр тодорхойлогдоно.

Соёлын бодлого¹ хэмээх нэр томъёог ЮНЕСКО 1969 оноос эхлэн дэвшүүлж, төрийн бодлогын салшгүй чухал хэсэг болгон гишүүн орнууддаа хэрэгжүүлэхийг уриалж, улмаар хэрэгжүүлэгч байгууллага болох "Соёлын яам"-ыг гүйцэтгэх засаглалынхаа бүрэлдэхүүнд зайлшгүй багтаахыг чухалчилсан байна. НҮБ-ийн боловсрол, соёл, шинжлэх ухааны төрөлжсөн байгууллага ЮНЕСКО-гоос 2001 онд "Соёлын олон төрөл зүйлийн тухай ЮНЕСКО-гийн Түгээмэл Тунхаглал"-ыг, 2003 онд "Биет бус өвийг хамгаалах тухай" конвенци, 2005 онд "Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг дэмжих тухай" конвенцийг тус тус батлан хэрэгжүүлсэн байна².

Өнөөгийн нийгмийн ариг гамгүй буюу хүний хэрэглээнд үндэслэсэн эдийн засгийн үйл ажиллагаа, зах зээл дээр соёл, соёлын үнэт зүйлс бараа, үйлчилгээний хэлбэрээр оршин байх нь ховор тохиолдол биш. Энэ нь соёлын бодлого, үйл ажиллагааг удирдах хоёр гол нөхцөлийн нэг болж байдагтай холбоотой юм. Түүнд эдийн засгийн нөхцөл байдал, хууль эрх зүйн нөхцөл байдал хоёр гол тулгуур болдог. Иймд дээрх нөхцөл байдал соёлыг удирдах хэлбэр, механизмын асуудлыг өөрийн эрхгүй сөхөж тавихад хүргэдэг. Соёлын бодлогын тухай асуудал юуны өмнө чухлаар гарч ирдэг.

Бидний амьдарч буй өнөө үед соёлын бодлогын асуудал бол нийгмийн социаль хүрээний эмзэг асуудал болоод байгааг зайлшгүй анхаарах хэрэгтэй. Гэхдээ урьд нь энэ асуудлыг судлаачид сонирхон оролдож байсан хэдий ч их төлөв үзэл сурталжуулан хэтэрхий ерөнхий

¹ Культурная политика: защита культурного наследия и содействие культурной свободе. Доклад о развитии человека – 2004. "Культурная свобода в современном многообразном мире. Изд. "Весь мир" М., 2004. стр. 44

² Х.Сампилдэндэв ба бусад "Монгол зан үйл, баяр ёслолын товчоон" УБ, 2006. х.5

байдлаар ард иргэдэд ойлгуулж байлаа. Жишээ нь, бүх нийтээрээ бичигтэн болох, боловсрол бүгдэд хүртээмжтэй байх, үзэл сурталжсан гэгээрлийн тодорхой зэрэглэл, урлаг болон соёлын бүхий л байгууллагуудыг төрөөс дэмжих, хүрээ соёлыг түгээн дэлгэрүүлэх, хөдөөний иргэдийг хотжуулах гэх мэт. Хуучин нийгмийн үеийн ангийн шинжтэй үнэлэмжийг хотжуулах гэх явдлыг үнэхээр тэсч, даван туулж ирсэн бидний монголчууд тэхин шүтэх дээд зан суртахуун, гоо сайхан, оюун ухааны болон түүнийг эрхэм баримжааллаар илэрдэг оюун санааны эрх чөлөө, үнэлгээний шашны чиг дээр тулгуурласан нийт хүн төрөлхтний үнэлэмжид нийцүүлэх, плюрализм зэрэгцэн орших хүслээ гүйцэлдүүлэхийг оролдож байна.

Соёлын бодлого ба Үндсэн хууль. XX зууны монголын ард түмний төрт ёсны нэг том ололт бол төрийн бодлогын бүрэлдэхүүн ард түмний "соёлын бодлого" төлөвшсөн үйл явдал юм¹. Түүнчлэн төрийн хэсэг болон зонхилох гол цөм болон соёлын бодлого төлөвших болсныг НҮБ-ын 2004 оны Хүний хөгжлийн илтгэлийг "Олон янз ертөнц дэх Соёлын бодлогын нэртэйгээр туурвиснаас илт харагдах төдийгүй Монгол улсын 1992.01.13-нд баталсан бидний "шинэ" хэмээдэг "Үндсэн хууль"-нд энэ агуулга бүрнээ тусгагдсан байна гэж үзэх үндсэн дээр энэхүү өгүүллийг тэрлэсэн болно. Уг хуулинд иргэний үндсэн эрх, эрх чөлөөний нийт 18 заалтыг тэрлэсэн болно. Социалист нийгмийн төрөөс баримтлах соёлын бодлого бүрнээ өөрчлөгдөх хөрс суурь болж өгсөн төдийгүй өмнөх 1924, 1940, 1960 онуудын БНМАУ-ын социалист хэв загварын үндсэн хуулиудаас үндсээрээ тусгасан байдал болоод соёл хэмээх үгийг хэрэглэсэн тоо агуулгаараа илт давуутай хууль болсоныг тодотгох үүднээс асуудалд хандаж байгаа болно?

Анхны Үндсэн хуулинд соёл хэмээх үг цор ганц удаа "эрдэм соёл" гэсэн хэллэгээр багтсан бол удаахь үндсэн хуулинд "соёл боловсрол" гэсэн хэллэгээр, мөн хуулийн 1949 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн 9 дүгээр тогтоолын хавсралтаар "соёлын нийгэмлэг" гэсэн ойлголт нэмэгдэн орж иржээ⁴. Мөн хуулинд 1957 оны нэмэлт өөрчлөлтөөр "соёлын хэлтэс" байхаар санал оруулж батлуулсан байна.

1960 оны Үндсэн хуулиар бол социалист соёл, соёлын хэмжээг хэлбэрэлтгүй дагаж мөрдөхийг заасан байна. Энэ бүгдээс үзвэл өмнөх гурван удаагийн үндсэн хуулинд соёлын агуулгыг ихэвчлэн боловсрол, эрдэм гэгээрлийн агуулгаар ойлгож байсан нь уг асуудлыг эрхэлж байсан яам нь гэгээрлийн болон боловсролын яам нэртэй байснаас харагдах төдийгүй орчин цагийн монгол хэлэнд ард иргэд үр хүүхдээ бүх шатны сургууль боловсролын байгууллагад элсэн суралцахыг "сургууль соёлд орох" гэсэн хэвшмэл хэллэгээр өгүүлдэг болсон нь өмнөх гурван үндсэн хуулийн агуулгаас улбаатай гэлтэй.

Харин 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулинд соёл хэмээх үг болон хуулийнхаа үндсэн эрхэм зорилгод соёлыг дараах заалттайгаар буюу -

¹ А.Энхбаатар, И.Лхагвасүрэн "Монгол улсын үндсэн хуулиуд ба соёлын бодлого" // Соёл судлаач багш нарын үндэсний IV семинарын материал. УБ., 2006.06.10. х.8

² А.Энхбаатар, И.Лхагвасүрэн "Монгол улсын үндсэн хуулиуд ба соёлын бодлого" // Соёл судлаач багш нарын үндэсний IV семинарын материал. УБ., 2006.06.10. х.16-18

³ БНМАУ-ын анхдугаар үндсэн хууль. 1-р бүлэг. 1-р зүйл. //Монгол улсын үндсэн хууль. Баримт бичиг. Ж.Амарсанаа, О.Батсайхан УБ., 2004. 42 дахаа тал.

⁴ Мөн тэнд, 164 дэх тал.

төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж," "-хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх"¹-ийг эрхэм зорилгоо болгох талаар үндсэн хуулийнхаа магнайдаа залсанаар уг хуулийн заалтууд эхэлдэг бөгөөд хүний эрхийн заалтын хэсэгт "соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална"² хэмээн тодотгон заасан нь өмнөх хуулиуд дахь монгол төрийн соёлын бодлого үндсээрээ өөрчлөгдсөнийг харуулж байна. Эдгээр хуулийн заалтыг монгол хүн бүр мэдэх боловч соёл гэдэг үгийг өмнөх үндсэн хуулиудад ийнхүү эрхэм зорилгийнхоо болон эхний хэсэг бүлгүүдэд зааж байгаагүйг онцолж буй хэрэг бөгөөд цаашилбал соёл хэмээх үгийг жинхэнэ сонгодог утгаар нь лавтайяа зургаан удаа хэрэглэсэн төдийгүй эдгээр заалтууд нь бүгд өмнө өгүүлсэнчлэн хуулийн эрхэм зорилго болон нэгдүгээр бүлэг болох "Монгол Улсын бүрэн эрхт байдал" заалтын хэсэгт оруулж өгсөн нь соёлын тусгаар байдал, төрийн бүрэн эрхт байдлын баталгаа болж өгсөн төдийгүй соёлын бодлого төрийн бодлогын цөмийг бүрдүүлж байна гэж үзэх үндэстэй юм. Мөн энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд **хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх** гэсэн үндсэн хуулийн заалт харин иргэншил гэсэн утгаараа хэрэглэсэн үү эсвэл соёл ба иргэншил гэсэн утгаар хэрэглэгдсэн эсэх талаар хуулийн тайлбар хийх боломжтой гэсэн саналыг дэвшүүлж байна. Энд нэгэн таслалын асуудал л байж болох юм.

Соёлын бодлого бол олон үе давхраа бүхий тогтолцоо юм. Соёлын бодлогын нэг хэсэг бол төрийн хэлний бодлого гэдэг нь эргэлзээгүй юм. Энэ талаар үндсэн хуулийн наймдугаар зүйлд монгол хэлээ хууль зүйн хувьд төрийн хэлээр баталсан нь төрийн хэлний бодлогын суурь болж өгсөн бөгөөд хожим 2003 онд "ТӨРИЙН АЛБАН ЁСНЫ ХЭЛНИЙ ТУХАЙ" хуулийг батлан гаргасан билээ. Уг хуулийн заалтаас хэрэгжихгүй байгаа олон зүйл байгаагийн нэг бол албан байгууллагуудын хаяг монгол хэл бичгээр байх тухай заалт юм.

Соёлын ялгаа хамгийн түрүүнд хэлэндээ илэрдэг болохыг соёлын онол, хэлний соёл судлаачид ямагт өгүүлэх бөгөөд хэлний ялгаатай байдал болон түүнийг үл мэдэхийн бэрхшээл хувь хүнийг нэн тэргүүнд соёлын шоконд оруулдаг болохоор жишээлж болно. Тэгвэл бид эх орондоо байгаа хэрнээ албан газруудын нэр хаягийг уншиж чадахгүйд хүрэх явдал олонтой тохиолдох төдийгүй нийслэлийнхээ зарим дүүрэг хороогоор явж байхад хятадын аль нэгэн гудам талбайгаар явж байгаа мэт сэтгэгдэлийг хүртэл төрүүлнэ.

Төрийн соёлын бодлого түүний хэрэгжилтийн бас нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол хэдийгээр зарим тохиолдолд соёлын бүх хүрээг хамардаг улс төрийн соёлын үзэгдэл болох төрийн бэлгэ тэмдэг, түүний илрэл болох төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулалыг хэрхэн хэрэглэх болон утгын бэлгэдлийн хувьд хэрхэн ойлгохыг арван хоёрдугаар зүйлд зааж өгсөн явдал юм. Энэ бол соёлын уламжлал бахархал зорилгоо илтгэн харуулдаг нэн чухал үзэгдэл элементүүд юм. Энэ бүхэн нь мөн төрийн бүрэн эрхт байдлыг илтгэн харуулдаг нь хэнд ч илэрхий. Төр төдийгүй иргэн

¹ Монгол Улсын Үндсэн хууль УБ., 1992

² Монгол Улсын Үндсэн хууль УБ., 1992

хүртэл энэ л төрийн бэлгэ тэмдэгээрээ өөрийгөө болон эх орноо дотоод гадаадад төлөөлж байдгаараа соёлын хувьд хосгүй шинжтэй.

Төрийн соёлын бодлого болон соёлын үзэгдлийн хамаарлын хүчин зүйлийг илтгэх үзэгдэл бол ард түмний төлөөлөл болсон УИХ-д сонгогдсон гишүүний бүрэн эрх хуулиар Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр буюу соёлын агуулга, бэлгэдлийн хувьд монгол үндэснийхээ уламжлалт соёлын дээд үнэт зүйлсэд сөгдөн мөргөснөөр эхэлж байгааг бахархалтайяа тайлбарлах боломжтой юм. Тухайлбал монголчуудын мөнх хөх¹ тэнгэрийг дээд буюу төрийн уламжлалт шүтээн болгосон талаар монголчуудын уламжлалт соёлын хөгжилд хөхийн урсгал түрлэг болсон² зэргийг төрийн сүлдний тайлбарт эгнэгт багтаасан нь тодорхой байна.

Соёлын бодлогыг эртний домог үлгэрт гардаг кентавр³-тай зүйрлэж болно. Нэг талаар органик хөгжлийн зайлшгүй нөхцөл болох оюуны эрх чөлөөг, нөгөө талаар нэг хэсгийг нөгөөгөөр нь ноёлуулж, нийгмийн хувьд албадан, улс төрийн амьдралын дүрмийг тогтоон, түүнийг удирддаг гол шинж бүхий засаглалтай шууд холбон авч үзэж болно. Дэлхий дээр өнөө улс орон бүхэн өөр өөрсдийн соёлын давамгайллын төлөөх бодлогыг хэрэгжүүлж байна гэж үзэж болно. Иймд тэдгээр улс орны иргэншил хоорондын мөргөлдөөнд хэн ялах вэ? гэсэн асуулт гарч ирсэн талаар С.Хантингтоноос эхлэн өгүүлэх болсон байна.

Засаглал мэдээжээр соёлыг нийгмийн нийтлэг эрх ашиг, сонирхолд нийцүүлэн үзэл сурталжуулахыг эрмэлздэг бөгөөд түүнийг соёл судлалд доминант буюу зонхилох соёл гэдэг. Үүнээс үзвэл зонхилох соёлыг тогтоон барихад төрөөс баримтлах соёлын бодлого шууд нөлөөтэй болох нь харагдаж байна. Харин нөгөө талаас бол зонхилох соёл гэдэг бол угаас төрийн бодлого ажээ. Засаглалын гол үндсэн зорилго бол эдийн засгийн хүч чадлыг монопольчлох явдал юм. Засаглал, эдийн засаг хоёр нягт харилцан холбоотой байхад соёл нь өөрөө харьцангуй бие даах чадвартай байх жишээтэй. Иймээс соёл аль болох улс төрийн нөхцөл байдал, шийдвэрээс харьцангуй тусгаар байх нь чухал. Гэвч улс төрийн засаглал өөрийн оршин байсан бүхий л хугацаанд соёлын үнэт зүйлсийг өөрийнхөө ашиг сонирхолд нийцүүлэн хэрэглэж, түүнийг ашигласаар ирсэн билээ.

Соёлын бодлогыг төрийн засаглал өөрөө анх бий болгосон. Ийм учраас төрийн засаглал түүнийг томъёолж, эцсийн бүлэгт хэрэгжүүлдэг. Соёлын бодлогын бүтцэд үнэт зүйл, үзэл суртал, үзэл баримтлалын агуулга багтахын зэрэгцээ эдийн засаг, эрх зүйн бүрэлдэхүүнүүд онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Шинэ мянганы эхэн үе дэх монголын соёлын бодлогын бэрхшээлүүд нь санхүү, эрх зүйн төдийгүй үзэл баримтлалын шинжтэй гэдгийг анхаарах хэрэгтэй. 1990-ээд оны шинэчлэлийн эхэнд монгол улс дэлхийн соёлын

¹ Хөх хэмээх үгийн болон хөх мөнх тэнгэрийн шүтлэгийн улбааны талаар Ю.Болдбаатар "Хөхдэй мэргэн од, түүний домгийн учир холбогдол" // Mongolian journal of anthropology, archeology and ethnology. Volume 2, № 1(254)January 2006. P.152-162 бүтээлээс үзнэ үү.

² Б.Пүрэвсүрэн "Монголын уламжлалт нийтийн соёл дах "хөхийн урсгал"" //Соёл судлаач багш нарынүндэсний V семинарын материал. УБ.,2007.х:60-63

³ Энэ зүйрлэл нь соёлын бодлого хоёрдмол уг чанар, эхлэлтэй байх буюу хөгжлийн гибрид замналыг илэрхийлж буй хэрэг юм. Кентавр гэдэг үг өөрөө грек гарвалаараа kentauros, латин бичиглэлээрээ Centaurus гэсэн үг бөгөөд хүн толгойтой, морин цээжтэй домгийн амьтны нэр юм.

орон зайд нэгдэн нийлж, улмаар нийт үндэсний менталитетүүдийн ачаар хүн төрөлхтний үнэт зүйлсийг урьтал болгосон нь соёлын бодлогын хүрээнд хийсэн чухал алхам болсон билээ. Харамсалтай нь энэхүү соёлын бодлогын үзэл баримтлал нь улс төрчид төдийгүй нийгмийн зарим гишүүдэд дааж дийлшгүй ачаа болон хувирсныг бид санахгүй байх аргагүй. Энэ үед үндэсний эв нэгдлээр улс орноо хямралаас аварч болно гэсэн санаа ч дэвшигдэж эхэлсэн. Оросын нэрт эрдэмтэн, академич Д.С.Лихачев энэ тухай хэлэхдээ: "Бүх гай зовлонгоос нийт үндэстний тухай санааг аварна гэдэг бол ёстой энгийн тэнэг зүйл төдийгүй хамгийн аюултай тэнэглэл. Үндэстний санаагаар явсан амьдрал эхлээд зайлшгүй хавчигдалд хүргэж, дараа нь түүнийг үл тэвчих байдал үүсгэдэг. Нэгдмэл байдлаар сэтгэнэ гэдэг нь зохиомол зүйл. Олон янзаар сэтгэж, олон санаа гаргах нь жам ёс" гэжээ. Тэрээр цааш нь: "Бидний ирээдүй бол ертөнц болон соён гэгээрэлд нээлттэй байх явдал мөн"¹ гэж гайхамшигтай хэлжээ.

Бид соёлын бодлогын хувьд олон бэрхшээлтэй учирч байна. Үзэл баримтлалын байдлаар бие хүний оюун санаа, эрх чөлөөг тунхаглагдсан хэдий ч хууль эрх зүйн болон эдийн засгийн тал нь хангагдаагүйн улмаас практик дээр хэрэгжиж чадахгүй байна. Ийм учраас жил бүр НҮБ-аас эрхлэн гаргадаг "Хүний хөгжлийн тухай илтгэл"-ийн 2004 оны дугаарыг хүний соёлын эрх чөлөөг хангах сэдвийн доор бүтээн туурвисан байна. Өнөөгийн олон янз ертөнц дэхь соёлын эрх чөлөөг хангахын тулд төрийн бодлого дараах таван чиглэлд анхаарах ёстой ажээ. Үүнд улс төрийн амьдралд оролцох оролцоог хангах бодлого, шүтэн бишрэх эрх чөлөөг хангах бодлого, эрхийн плюрализмын бодлого, хэлний бодлого, нийгэм эдийн засгийн бодлого² зэрэг багтана. Монгол улсын хувьд дээрх бодлогуудыг тодорхой хэмжээгээр хангаж буй ч төдийлэн дорвитой үр дүнд өнөөг хүртэл хүрээгүй байна. Тухайлбал соёл болон урлаг хэмээх ойлголтыг хэрхэн ойлгож хүлээн авч байгаа нь нийгмийн ухамсар болон менталитетийн хувьд тодорхойгүй, түүнийг зааглан ялгах чадвар төлөвшөөгүй зэрэг бэрхшээлүүд хамгийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Соёлын бодлого бол соёлжсон ертөнцийн орчин үеийн амьдралын нэг чухал асуудал юм. Монголын их дээд сургуулиудад сүүлийн жилүүдэд "Соёл судлал" гэдэг хичээлийг 2 кредит цагийн хэмжээтэйгээр заах тухай БСШУ-ны сайдын тушаал гарсан нь соёлын тухай ойлголт төсөөллийг үнэн зөв ойлгуулах, түүний талаарх онц тодорхой мэдлэгийг тэдэнд олгох, соёлыг ойлгохуйн хүрээг монгол сэтгэлгээний хүрээнд өргөтгөн тэлэх зэрэг наад заахын ач холбогдолтой зүйл болсон гэж их дээд сургуулиудын соёл судлалын багш нар үзэж байна³. Харин европын их сургуулиудад "Соёлын бодлого ба төлөвлөлт" нэртэй хичээлийг заадаг болохыг бас анзаарахгүй байхын аргагүй юм.

¹ Лихачев Д.С. Единомыслие – искусственность // Известия. 1997. 27. нояб. // Теория культуры. стр. 271

² А.Энхбаатар "...НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн "Хүний хөгжлийн тухай илтгэл 2004"-ийг судлагдахуун болгон хэрэглэх асуудалд" // Философи, соёл судлал. ШУТИС-ийн ХУС-ийн ЭШБ. Уб., 2007. х. 11-12

³ Энэ дүгнэлтийн сүүлийн таван жилийн туршид явагдсан "Монголын соёл судлаач багш нарын семинар"-уудын материал, хэлэцүүлэг, бусад хөтөлбөрийн хэлэлцүүлгүүдээр үнэлж дүгнэсэн болно.

Манай улсын соёлын бодлого нилээд хэмжээгээр зогсонг, хямралын байдалтай байсан гэж үзэж болох юм. Учир нь нийгэм шилжилтийн үедээ байсан, иргэдийн хувьд гадаад болон дотоод цагаачлалын хэмжээ маш их байсан, улсын нийслэлийн хүн ам зохиомлоор тухай, мэргэжлийн урлагийн гэгдэх хотын соёлын өнгө төрх алдагдсан тухай, нийслэл болон байгууллага болон боловсон хүчний бодлого алдагдаж, нийслэл болон хөдөөгийн соёлын төвүүд үүдээ хааж, үйл ажиллагааныхаа хүрээг нэлээд хумисан, хаасан тухай ард иргэд өгүүлж байна.

Төрийн соёлын бодлого эцсийн дүндээ соёлын цөм үүрэг биелэгдэх нөхцлийг ханган, зохицуулж байх ёстой билээ. Энэ үүргээр бол соёл нь хүнийг хүмүүжүүлэн-бүтээх буюу гуманист-креатив үүрэгтэй¹ болох нь эргэлзээгүй.

Германы нэрт соёлын онолч, философич Гердерийн үзсэнээр бол соёлыг хүний хоёрдох төрөлт хэмээн үзсэнчлэн төрийн соёлын бодлого бол нийгэмд эрүүл мэндийн яам, эх нялхсын амаржих газар лугаа иргэнээ соёлын хувьд эрүүл эсэн мэнд дахин буюу хоёрдох төрөлтийг хангах, зохицуулах үүрэгтэй гэж үзэж болно. Энэ нь эцсийн дүндээ боловсрол, соёл, шинжлэх ухааны цогц үйл ажиллагаагаар биелэлээ олох учраас үүнд хамгийн анхаарал бага хандуулж монгол төр наанадаж гүйцэтгэх засаглалынхаа түвшинд соёлын агентлагтай болох шаардлага өмнө өгүүлсэн олон шаардлагаас урган гарч байна.

Тухайлбал, "Соёлын тухай" хуульд соёл судлалыг хөхүүлэн дэмжих, соёлын ажилтанг бэлтгэх гэх мэтээр заасан мөртлөө соёлын судлаачыг өөрсдийн багшлах боловсон хүч, сургалтын материаллаг бааз, сургуулийн гадаад харилцаа хамтын ажиллагааныхаа үр дүнд бэлтгэж байсан ШУТИС-д мэргэжилтэн бэлтгэхийг асуудал эрхэлсэн яам өөрөө хаан боогдуулж байгаа нь гавихгүй гавъяагүй юм аа гэхэд гай болохооргүй хүн буюу боловсон хүчин төрөн гарч буй гэдэгт эргэлзэхгүй байгаа тус сургуулийн багш нарын хувьд хүүхэд төрөх гээд байхад надад таалагдахгүй байна гээд хүчээр аборт хийлгэхийг шаардаад байгаа эцэг, эх лугаа адил санагдана. Эс тэгвээс бид чамтай эцэг эхийн холбоогоо үүрд таслана хэмээн айлгана. Гэтэл заримдаа /үүнийг онцолж байна/ өнчин ядуу өрөөл татанхай гэмээр /энэ бол дээд боловсролын шүүмжлэлтэй холбоотой зүйрлэл/ хүүхэд төрүүлж буй гэр бүл буюу зарим хувийн их, дээд сургуульд хүүхэд төрүүлэхийг төрөөс дэмжээд байгаа харалган халамжийн бодлого шиг үйл хэрэг болж байгаа мэт сэтгэгдэл тухайн хамт олны нэгэн болох миний биед төрдөг юм.

Иймэрхүү асуудал өөрөө байнга хувийн хэвшлийн их, дээд сургуулийг ялгаварлан гадуурхаж байна гэсэн ял зэмд унадаг болохыг бүгд мэдэх бөгөөд үүнийг өгүүлэгч би бээр харин ч монголд хувийн чанартай их дээд сургууль хурдан буй болж, өргөжин бүтцийн хувьд томрох нь олон талаар ач холбогдолтой гэж үздэгээ энэ дашрамд илэрхийлье.

Түүхийг сөхөж үзвэл соёлын бодлого төр үүссэн цагтай уялддаг. Соёлын бодлогын цар хүрээний өргөн тэлэлт нь XX зууны 30-аад оны үеэс л явагдаж эхэлсэн гэдэг. Энэ арга хэмжээг тоталитар төр идэвхитэй ашигласан нь санамсаргүй хэрэг биш юм. Учир нь тоталитар төр соёлыг

¹ Б.Пүрэвсүрэн "Соёлын үүрэг" // Соёл судлаач багш нарын үндэсний IV семинарын материал. УБ., 2006.06.10. х.70.

өөрийнхөө үзэл суртлын бамбай болгон ашиглаж ард олныг эрхшээлдээ барьж байв. Дараа нь соёлын бодлогыг ардчилсан төрт улс орнууд үр дүнтэй ашиглаж иржээ. Эдгээр орнуудад соёлын бодлого үзэл суртлын дарамтаас ангижирч, янз бүрийн хэлбэрээр хөгжих бололцоог олж авчээ.

Харин орчин үед соёлын бодлого даяарчлал болон дангааршлыг хэрхэн бодит байдалд зохистойгоор нийцүүлэн хэрэгжүүлэх вэ гэдэгт бүхийл улс орнууд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй болж байна. Даяаршлын эрин үе дэхь Монголын соёлын бодлогын дангааршлын үзүүр хэрхэн тусах талаарх саналаа эрдэмтэн зохиолч Л.Түдэв нэгэн бүтээлдээ¹ оновчтой илэрхийлсэн байна.

Ерөөс соёлын ялгаа бол нэн тэргүүнд хэлэндээ илэрдэг болохыг Гумбольдт болон Леви-Стросс нар онцгойлон тэмдэглэдэг төдийгүй Хантингтоны үзсэнээр бол өнөөгийн иргэншлийн ялгаа нь дэлхий ертөнц дээрх шашны ялгаа, түүний түгэн тархалтанд үндэслэгдсэн² болохыг универсаль иргэншлийн асуудлыг хөндөхдөө тэмдэглэдэг. Тэгэхээр шашны асуудал Үндсэн хуулинд нээлттэй тавигдсан нь монголчууд соёлын эрх чөлөөгөө эдлэх бас нэгэн чухал боломж нээгдсэн болохыг харуулна.

Соёлын бодлогын ангилал, хэв маяг. Соёлын бодлогын хэв шинжийн ихэд түгэн дэлгэрсэн ангилалууд байдаг³. Үүнд: "патерналист", "популист", "эклeктик", "социодинамик" хэв маяг багтана.

"Патерналист" хэв маяг: Патер гэдэг нь латин хэлний pater буюу эцэг гэсэн утгатай үг. "Соёлын удирдлагын гол судсыг төр өөрөө барих хэв маяг". Төрийн байгууллагууд ба соёлын хоорондын харьцааг дээрээс шууд тодорхойлно. Үүнд тоталитар төрийн соёлын бодлого эсвэл шашинжсан төрийн үйл ажиллагаа хамаарна.

"Популист" хэв маяг: Популист гэдэг нь латин хэлний popularis буюу ард түмэн, олон түмэн гэсэн утгатай үг. "Хүмүүс соёлын үнэт зүйлсээс чөлөөтэй хүртэх боломж бүрэлдүүлдэг соёлын харилцааг хэлнэ". Нилээд тохиолдолд үүнийг ардчилсан эсвэл либераль бодлого ч гэж нэрлэдэг.

"Эклeктик" хэв маяг: Эклeктик гэдэг нь латин хэлний Eklektikos буюу сонгох, түүвэрлэх гэсэн утгатай үг. "Соёлын үнэт зүйлсийн хувь хэрэглээний янз бүрийн хэлбэрээс хүртэхийг хэлнэ". Өөрөөр хэлбэл соёлын бодлогын давамгайлах зарчим энд үйлчлэхгүй гэсэн үг. Орчин үед аль нэгэн улс үндэстний болон хувь хүний соёлыг хүлцэн хүлээн авах буюу толерант зарчим соёлын эрх чөлөөг дээдэлдэг, түүний даллага авсан америк мэтийн улс орнуудын тэргүүлэх үнэт зүйлсийн нэг болоод байгаа нь энэ бодлоготой холбоотой юм. Харин нөгөө талд оюуны сав цоорох үзэгдэл явагдана.

"Социодинамик" хэв маяг: "Соёлын үйлчилгээ болон үнэт зүйлсийн хэрэглээнд зөвхөн тооны талыг голлон анхаарахыг хэлнэ".

Соёлын бодлогын хэв шинжийн өөр ангиллууд бас бий. Жишээ нь: төр соёлын хувьд "ивээгчийн", "инженерийн", "уран барилгачийн", "углуурга"-

□ "ДАЯАРШИЛ БА МОНГОЛ УЛС: Үндэсний болон хүний аюулгүй байдал" ЭШБХ-ын эмхатгал УБ, 2004 он.

² Самуэль П. Хантингтон "Иргэншил хоорондын мөргөлдөөн, Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам" Орч. Д. Баярхүү. МОНСУД УБ, 2005: х.33

³ Оганов. А.А., Хангельдиева. И.Г "Теория культуры" М., 2001 стр.284

н үүрэг гүйцэтгэх гэх мэт. Соёлын бодлогыг төр "ивээгчийн" байр сууринаас хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулагчдын сонирхлыг ашиглаж соёлыг санхүүгийн хувьд хөхүүлэн дэмжих, "инженерийн" дүрээр улс орны дэд бүтэц, иргэдийг хүмүүжүүлэх болон боловсролтой болгоход ашиглах талаар санаа тавих, "уран барилгачийн" дүрд тоглохдоо соёлын хөгжилд нөлөөлөх бүтцийн бүхэл бүтэн системийг цогцлуулах, "углуургын" үүрэг гүйцэтгэхдээ конкурс болон тендер зарлаж соёлын байгууллагуудад зээлийн хөрөнгө оруулалт хийх зэрэг болно.

Үүнээс үзэхэд соёлын бодлого нь соёлын удирдлагын аргуудтай салшгүй холбоотой болох нь илэрхий. Эдгээр арга нь ноёлон буй засаглалын хэлбэрээс шалтгаалж янз янз байх нь ойлгомжтой. Зарим арга хатуу чанд захиргаадалтын шинжтэй байхад зарим нь зөөлөн, уян хатан зохицуулж болох, өөр тохиолдолд өөрөө зохицуулагдах жишээтэй.

Манай монголын соёл олон арван жилийн турш захиргаадалтын системийн хатуу дарамтыг амсаж ирсэн төдийгүй их хэлмэгдүүлэлтийн он жилүүдэд соёлын өв, түүх дурсгалын зүйлүүд хүртэл хэлмэгдсэн тухай онго бодитойгоор өгүүлж байна. Хожим хэлмэгдэгсдэд зориулсан хөшөө дурсгалыг төрийн төв ордныхоо баруун талд харууслын бичээстэйгээр босгосон төр бол монголын төр юм.

Гэвч соёлын удирдлагын тогтолцоо шилжилтийн эдийн засгийн үед олон нарийн асуудалтай тулгарсан юм. Үүний тулд хөгжингүй эдийн засагтай орнууд дахь соёлын удирдлагын системийг идеал загварын хэлбэрээр харж судлах явдал чухал байх нь дамжиггүй. Дараа нь өөрийн орны нөхцөлд тохирсон хувилбар бүтээх нь чухал. Тухайлбал М.Веберийн хэлсэн "хамгийн хүнд урлаг бол удирдах урлаг" гэснийг санах хэрэгтэй. Харин соёлыг удирдах урлаг бол онцгой хүнд урлаг гэж нэмж хэлэх нь зүйтэй. Магадгүй тийм ч учраас соёлын асуудал эрхэлсэн монгол төрийн сайд өөрөө улсын их хурлын танхимд "... би энэ асуудлыг сайн мэдэхгүй" хэмээн үнэнээ өгүүлсэн бол түүнийг уучилж болох биз ээ.

Өнөөдөр манай орны соёлын хувьд хамгийн хурцаар тавигдаж буй асуудал бол соёлын санхүүжилтын асуудал. Зах зээлд шилжих үед соёлын бүх байгууллагад санхүүжилт хүрэлцэхгүй гэдэг нь ойлгомжтой асуудал. Учир иймд төсвөөс гадуурх санхүүжилтын эх сурвалжийг эрж хайх нь чухал. Энэ ажил манай орны хувьд шинэ, харин европын орнуудын хувьд эртний уламжлалтай. Европын орнуудад соёлын санхүүжилтыг төсвийн бус эх сурвалжаар хангах асуудал ямагт чухал асуудал байсаар иржээ.

Монголын төрөөс баримтлах соёлын бодлого ба эрх зүйн орчин
Монголын төрийн соёлын талаарх бодлогыг мэдэхийн тулд юуны өмнө Үндсэн хуулийн зүйл заалт агуулгатай танилцах ёстой болохыг сэдвийн эхэнд өгүүлсэн билээ. Түүнээс хойш монголын соёлын харилцааг зохицуулахын тулд удаа дараа хууль тогтоомж гаргаж түүнийгээ хэрэгжүүлсээр нийгмийн шинэ зохион байгуулалтанд шилжин орсон байна. Үндсэн хуулийнхаа агуулгад нийцүүлэн соёлын харилцааг иж бүрэн зохицуулахын тулд: 1996 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Соёлын тухай хуулийг дараах зорилттойгоор буюу

"Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад соёлын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэс, соёлын үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, соёлын удирдлагын тогтолцоо, соёлын ажилтны нийгмийн халамж баталгаа, соёлын

байгууллагын өмч, санхүүжилтийн зарчим, арга хэлбэрийг тогтоож, уг үйл ажиллагаанд оролцогчдын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино", 2001 оны 06 дугаар сарын 08-ны өдөр "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулийг дараах зорилттойгоор буюу

"Энэ хуулийн зорилт нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж, хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино", 2003 оны 05 дугаар сарын 15-ны өдөр "Төрийн албан ёсны хэлний тухай" хуулийг дараах зорилттойгоор буюу

"Энэ хуулийн зорилт нь төрийн албан ёсны хэл болох монгол хэл /цаашид "төрийн албан ёсны хэл" гэх/-ний хэм хэмжээ, нэр томъёог төрийн албан хэрэг хөтлөх, төрийн албан ёсны үйл ажиллагаанд хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулах болон Монгол Улсын нэгдмэл байдлыг хангахад оршино" заалттайгаар тус тус батлан гаргасан нь монголын төрөөс баримтлах соёлын бодлого, түүний харилцааг зохицуулах эрх зүйн үндэс болж байгаа юм.

Энэ бүхнээс гадна "Нийтээр тэмдэглэх баяр ёслолын тухай" хууль, "Үндэсний их баяр наадмын тухай" хууль, "Төрийн бэлгэдлийн тухай" хууль зэргийг батлан гаргасан нь тухайн асуудлуудыг зохицуулах гол эрх зүйн актууд болж байна.

Мөн "Монголын төрөөс баримтлах соёлын бодлогын мастер төлөвлөгөө" хэмээх баримт бичгийг боловсруулах тухай олон жил хэлэлцэгдэж байна. Гагцхүү 1992 оны "Үндсэх хууль"-нд урьдын цагт хаалттай байсан "төрт ёс, түүх, соёлынхоо уламжлал"-ыг нандигнах, "хүн төрөлхтний соёл иргэншлийн ололт"-ыг хүндлэн шүтэх, соёлын өв, соёлын уламжлал зэрэг ойлголтуудыг сонгодог утгаар нь оруулж өгсөн зэрэг олон онцгой чухал заалт тусгагдсан байдаг.

Дүгнэлт

Аливаа соёлын ялгаа бүхэн төрөөс баримтлах соёлын бодлого түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны биелэл, хэрэгжилт болно. Соёлын ялгаа нэн тэргүүнд хэлэндээ, иргэншлийн ялгаа орчин үед шашиндаа илэрч байгаад үндэслэн төрийн соёлын бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй болж байна. Монгол улсын иргэн бүрийн залбирал, түүний даллага нь монгол үндэсний соёл байхуйцаар төрийн соёлын бодлого хэрэгжсэнээр хүн эцэг эхээс нэгэнтэй төрж, эрүүл соёлын орчноос хоёронтой төрөх боломжийг иргэн бүрдээ тэгш олгох ёстой.

Монгол төр, монголын ард түмний эрхэм зорилгыг монгол соёлтой холбосон үндсэн хуулийнхаа агуулгыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөхийг тэртээ тэргүй иргэний үндсэн үүрэг хэмээн заасан арван долдугаар зүйлийн заалтыг соёлын үүрэг лугаа дэлгэрүүлэн тайлбарлах хууль эрх зүйн боломж нээлттэй байна. Дэлхий нийтээрээ соёлын бодлогыг төрийн бодлогынхоо цөм болгож байгаа жишээг монгол улс гарцаагүй даган мөрдөж түүнд түлхүү анхаарал тавих цаг нэгэнт иржээ.

Монгол хүн монгол эх, монгол эх нутаг, монгол эх хэлнээсээ буюу монгол соёлын эм үүтгэлээс дахин дахин төрж байхыг ерөөх бус ертөнц

дахинаа хэрэгжүүлэх нь монгол төрийн соёлын бодлогын даяарчлалын эрин үе дэх цар хүрээг тодорхойлно.

Монгол улсын үндсэн хууль бол өмнөх үндсэн хуулиудтай соёлын бодлогын хувьд харьцуулан үзвэл жинхэнэ соёлын бодлоготой үндсэн хууль болжээ. Соёлын бодлогын хэрэгжилт бол хувь хүнийг хэн байх, хэрхэн амьдрахаа сонгох явдал бөгөөд соёлын эрх чөлөөний дуудлага болсон "цэвэр" агаар буюу соёлын үнэт зүйлсээр "сэлүүхэн амьсгалах" нөхцөлийг хэлдэг байна.

Заключение

Цикл культурной политики должен завершиться возвращением туда, где он начался четверть века назад – к людям, к их культурной свободе и наполненности – основной цели реализации культурной политики.

Культурная свобода – это возможность людей выбирать свою идентичность и вести образ жизни без ущемления в возможностях выбора в отношении образования, медицинского обслуживания и работы.

Культурная свобода – это способность людей выбирать, как жить, и кем быть.

Реализация культурной политики означал содействие искусству и защиту культурного наследия.

Культурная свобода является важнейшей составляющей человеческого развития, потому что для полноценной жизни индивиду абсолютно необходимо определить свою идентичность.

Ашигласан ном зохиол

"ДАЯАРШИЛ БА МОНГОЛ УЛС: Үндэсний болон хүний аюулгүй байдал" ЭШБХ-ын эмхатгал УБ., 2004 он.

Ерасов Б.С. "Социальная культурология" М., 1994. Ч.1. стр.318-354

"Культурология. XX век. Энциклопедия" В 2 т. СПб., 1998

Монгол улсын үндсэн хууль. Баримт бичиг. Ж.Амарсанаа, О.Батсайхан УБ., 2004. 42 дахаа тал.

Культурная политика: защита культурного наследия и содействие культурной свободе.

Доклад о развитии человека – 2004. "Культурная свобода в современном многообразном мире. Изд. "Весь мир" М., 2004.

Б.Пүрэвсүрэн "Монголын уламжлалт нийтийн соёл дах "хөхийн урсгал"" //Соёл судлаач багш нарынүндэсний V семинарын материал. УБ., 2007

Б.Пүрэвсүрэн "Соёлын үүрэг" // Соёл судлаач багш нарын үндэсний IV семинарын материал. УБ., 2006

Соёлын онол. Ред. Д.Дагвадорж УБ. 2003. х.157-169

Х.Сампил дэндэв ба бусад "Монгол зан үйл, баяр ёслолын товчоон" УБ., 2006

Оганов.А.А, Хангельдиева.И.Г "Теория культуры" М., 2001

С.Хантингтон "Иргэншил хоорондын мөргөлдөөн..." Орч. Д.Баярхүү УБ., 2006

А.Энхбаатар, И.Лхагвасүрэн "Монгол улсын үндсэн хуулиуд ба соёлын бодлого" // Соёл судлаач багш нарын үндэсний IV семинарын материал. УБ., 2006.

А.Энхбаатар "...НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн "Хүний хөгжлийн тухай илтгэл 2004"-ийг судлагдахуун болгон хэрэглэх асуудалд" //Философи, соёл судлал. ШУТИС-ийн ХУС-ийн ЭШБ. УББ., 2007